

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн талаар	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаар	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Санал, дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	11
4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5. Аудит хийсэн Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ АЖ
ҮЙЛДВЭРИЙН НЭГДЛИЙН ДАРГА
С.БААСАНХҮҮ ТАНАА

2020.03.13 № 06/822
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын дарга С.Баасанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамжийг боловсронгуй болгох, сайжруулах, авлага, өр төлбөрийг барагдуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Дөлгөөнхайрхан уул Аудит” ХХК-ийн аудитор Н.Янжмаа, аудиторовын туслах П.Сувд-эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь Батлан хамгаалах яамны харьяа төрийн өмчит үйлдвэрийн газруудыг менежментийн нэгдсэн удирдлагаар хангах, батлан хамгаалах аж үйлдвэрийн чадавхыг дээшлүүлэх, гадаад дотоод зах зээлд зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн худалдаа зохион байгуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэгслийг экспортлох, импортлох
- Цэвэр усны үйлдвэрлэл, худалдаа
- Гадаад худалдаа

Байгууллагын удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Татварын багц хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхой тусгаж харуулаагүй гэж дүгнэсэн.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Винница” программ хангамж ашиглаж байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 18 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 455.5 сая төгрөгөөс тооцон 4.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 6.6 сая төгрөгөөр тооцож, баталгаажуулав.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн талаар

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,231.8 сая төгрөгөөр буюу 297.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, өр төлбөр данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,398.1	5,024.3	3,626.2
Дансны авлага	15.2	4.0	-11.2
Бараа материал	183.0	162.8	-20.2
Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,762.0	10,431.3	7,669.3
Үндсэн хөрөнгө	1,341.5	1,309.2	-32.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,699.8	16,931.6	11,231.8
Өр төлбөрийн нийт дүн	4,285.8	15,518.5	11,232.7
Эздийн өмчийн дүн	1,414.0	1,413.1	-0.9
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	5,699.8	16,931.6	11,231.8

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн тайлангаар материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө дансны 4,766.1 сая, урьдчилж төлсөн зардал дансны 10,431.3 сая төгрөг нь Батлан хамгаалах яамны захиалгаар 7 төрлийн худалдан авах ажиллагаа гүйцэтгэж байгаатай холбоотой ба нууцын зэрэглэлтэй тул Батлан хамгаалах яамтай тооцооны үлдэгдлийн баталгаа гаргуулж, баримтжуулав.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага буурснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2012-2017 онуудад үүссэн, он удаан жил болсон 3.2 сая төгрөгийн хувь хүнээс авах авлага нь шүүхийн шатанд яваа бөгөөд найдваргүй болох эрсдэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд 2014-2018 оны баримтад хийсэн татварын шалгалтаар тогтоосон актын төлбөр, урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны нийт үлдэгдлийн 99.6 хувь нь Батлан хамгаалах яамны захиалгаар худалдан авах 7 төрлийн зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгсэл худалдан авах ажиллагаатай холбоотой 15,462.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

Бусад 0.5 сая төгрөгийн өр төлбөр нь 2019 оны 12 сард байгууллагатай холбоотой үүссэн ба тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

2.9 Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаар

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 494.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 471.8 сая төгрөгийн зардал гаргаж, 23.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар бизнес төлөвлөгөө боловсруулж, байгууллагын даргаар батлуулсан байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь тайлант онд гүйцэтгэлээр 674.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 655.9 сая төгрөгийн зардал гаргаж, орлогын төлөвлөгөөг 179.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, зардлыг 184.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Өөрийн үйл ажиллагаанаас олох орлогоо 202.7 сая төгрөгөөр давуулан бүрдүүлсэн боловч төлөвлөсөн бусад орлого 23.0 сая төгрөгөөр буурсан байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь тайлант онд гүйцэтгэлээр зардлыг 184.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг 156.8 сая төгрөг, үйл ажиллагааны бус ашиг алдагдал 27.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 чиглэлээр 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй бөгөөд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Батлан хамгаалах яамнаас санхүүжүүлдэг төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, түүний бүртгэлийг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 34.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 1.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 33.7 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс 1 актыг барагдуулж, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

2.14. Санал, дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

- 3.1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд нийт 4.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнаснаас 3.2 сая төгрөгийн авлага нь шүүхийн шатанд, 0.8 сая төгрөг нь 2019 оны 12 сарын 25-ны борлуулалттай холбоотой авлага байна. Нийт 56.5 сая төгрөгийн өглөгөөс 56.0 сая төгрөгийн өглөг нь татварын өр ба үүнээс 43.5 сая төгрөг нь 2019 онд 2014-2018 оны баримтад хийсэн татварын шалгалтаар тогтоосон актын төлбөр байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д *"татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"* гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.1.2 Эрсдэл: Авлага, өр төлбөр барагдахгүй байх, найдваргүй авлага үүсэх.
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан *"татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"* гэсэн заалтыг мөрдөж ажиллах.
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2019 онд татварын шалгалтаар илэрсэн зөрчлийн ногдол нь 2014-2017 онуудад үүссэн татварын төлбөр болно. Бид цаашдаа татварын хууль, эрх зүйн баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар аргачлалыг мөрдөж ажиллана.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхой тусгаж шинэчлээгүй, санхүүгийн программ хуучирсан, сайжруулалт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"* гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.2.2 Эрсдэл: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавартай нийцэхгүй байх.
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан өөрчлөлт оруулах, санхүүгийн программ хангамжид сайжруулалт хийх.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2020 оны байгууллагын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,398,058,171.85	5,024,265,909.77
1.1.2	Дансны авлага	2,198,500.01	2,198,500.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	11,968,022.58	
1.1.4	Бусад авлага	1,000,000.00	1,774,900.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	183,030,345.67	162,843,044.33
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,762,054,846.00	10,431,325,147.17
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,358,309,886.11	15,622,407,501.27
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,180,352,845.74	1,148,079,062.80
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	161,150,000.00	161,150,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,341,502,845.74	1,309,229,062.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,699,812,731.85	16,931,636,564.07
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	25,205,214.97	500,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	-	56,009,676.67
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,260,563,743.00	15,462,007,454.84
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг хөрөнгө/-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,285,768,957.97	15,518,517,131.51
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		

2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,285,768,957.97	15,518,517,131.51
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	2,821,123.00	336,725,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	269,265,689.31	269,265,689.31
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	610,304,759.30	276,400,882.30
2.3.9	Хуримтлагдсан ашиг	531,652,202.27	530,727,860.95
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,414,043,773.88	1,413,119,432.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИН ДҮН	5,699,812,731.85	16,931,636,564.07

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	198,710,008.80	478,514,003.02
2	Борлуулалтын өртөг	214,119,927.41	396,389,850.98
3	Нийт ашиг /алдагдал/	(15,409,918.61)	82,124,152.04
4	Түрээсийн орлого	2,672,727.27	
5	Хүүгийн орлого	11,216,494.96	31,842,636.31
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	462,421,539.04	164,147,208.16
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	234,882,344.99	210,666,440.52
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(49,924.19)	36,578,512.97
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(262,691,265.37)	(2,700,000.13)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг /алдагдал/	(99,681,791.19)	(46,112,255.47)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(136,404,483.08)	55,213,813.36
19	Орлогын татварын зардал	22,601,849.76	10,402,606.90
20	Татварын дараах ашиг /алдагдал/	(159,006,332.84)	44,811,206.46
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(159,006,332.84)	44,811,206.46
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз /гарз/		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,821,123.00	-	610,304,759.30	484,922,212.45	1,098,048,094.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				205,736,322.66	205,736,322.66
3	Залруулсан үлдэгдэл	-			690,658,535.11	690,658,535.11
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/				-159,006,332.84	-159,006,332.84
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг				-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		269,265,689.31			269,265,689.31
9	2018 оны 12 сарын 31 -ний үлдэгдэл	2,821,123.00	269,265,689.31	610,304,759.30	531,652,202.27	1,414,043,773.88
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-45,735,547.78	-45,735,547.78
11	Залруулсан үлдэгдэл	2,821,123.00	269,265,689.31	610,304,759.30	485,916,654.49	1,368,308,226.10
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/				44,811,206.46	44,811,206.46
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт	333,903,877.00	-	-333,903,877.00		-
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-	-
17	2019 оны 12 сарын 31 -ний үлдэгдэл	336,725,000.00	269,265,689.31	276,400,882.30	530,727,860.95	1,413,119,432.56

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн /+/ Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого Эрхи йн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө Буцаан авсан албан татвар Татаас, санхүүжилтын орлого Бусад мөнгөн орлого	4,223,946,261.63 237,600,078.00 1,311,198.00 338,052,060.00 3,646,982,925.63	11,997,505,773.47 566,527,175.00 81,170.00 9,962,085,096.00 1,468,812,332.47
1.2	Мөнгөн зарлагын дүн /-/ Ажилчдад төлсөн Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн Бараа материал худалдан авахад Ашиглалтын зардалд төлсөн мөнгө Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн Хүүний төлбөрт төлсөн Татварын байгууллагад төлсөн Даатгалын төлбөрт төлсөн Бусад мөнгөн зарлага	3,425,817,846.91 131,265,473.00 29,426,659.26 140,498,856.82 34,041,728.43 8,785,760.00 162,107,427.94 2,317,920.71 2,917,374,020.75	8,386,750,671.86 159,252,311.00 37,230,937.43 257,390,387.02 26,055,586.17 11,143,700.00 76,386,961.44 7,819,290,788.80
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	798,128,414.72	3,610,755,101.61
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн /+/ Үндсэн хөрөнгө борлуулсны орлого Биет бус хөрөнгө борлуулсны орлого Хөрөнгө оруулалт борлуулсны орлого Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт Хүлээн авсан хүүний орлого Хүлээн авсан ногдол ашиг		31,842,636.31 31,842,636.31
2.2	Мөнгөн зарлагын дүн /-/ Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	4,796,900.00 4,796,900.00 	16,390,000.00 16,390,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,796,900.00	15,452,636.31
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	793,331,514.72	3,626,207,737.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	604,726,657.13	1,398,058,171.85
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,398,058,171.85	5,024,265,909.77


4.5 Аудит хийсэн Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2018 оны гүйцэтгэл	2019 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	675,020,770.07	494,850,000.00	674,503,847.49	179,653,847.49	136.3
1.1	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний орлого	462,421,539.04	162,000,000.00	162,097,208.16	97,208.16	100.1
1.2	Усны үйлдвэрийн борлуулалт	198,710,008.80	275,800,000.00	478,514,003.02	202,714,003.02	173.5
1.3	Хүүний орлого	11,216,494.96	55,000,000.00	31,842,636.31	-23,157,363.69	57.9
1.4	Хөрөнгийн орлого	2,672,727.27	2,050,000.00	2,050,000.00	-	100.0
2	Нийт зардал	811,425,253.15	471,828,800.00	655,868,547.10	184,039,747.10	139.0
2.1	Ерөнхий ба, удирдлагын зардал	234,882,344.99	211,653,200.00	210,666,440.52	-986,759.48	99.5
2.2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	214,119,927.41	239,595,600.00	396,389,850.98	156,794,250.98	165.4
2.3	Үйл ажиллагааны бус ашиг алдагдал	362,422,980.75	20,580,000.00	48,812,255.60	28,232,255.60	237.2
3	Татварын өмнөх ашиг	136,404,483.08	23,021,200.00	18,635,300.39	- 4,385,899.61	80.9
4	Цэвэр ашиг	159,006,332.84	15,014,080.00	8,232,693.49	- 6,781,386.51	54.8
5	Төсвийн төлбөрт нийт дүн	214,135,936.96	90,236,567.00	85,668,827.31	-4,567,739.69	94.9
5.1	Орлогын албан татвар	22,601,849.76	8,007,120.00	10,402,606.90	2,395,486.90	129.9
5.2	НӨАТ		21,800,000.00	35,316,926.80	13,516,926.80	162.0
5.3	НДШ	29,426,659.26	26,661,732.00	21,000,107.87	- 5,661,624.13	78.8
5.4	Хүн амын орлогын татвар	162,107,427.94	17,891,715.00	12,961,148.14	- 4,930,566.86	72.4
5.5	Үл хөдлөх хөрөнгийн татвар		15,756,000.00	5,868,607.60	-9,887,392.40	37.2
5.7	Тээврийн хэрэгслийн татварт		120,000.00	119,430.00	-570.00	99.5
7	Нийт ажиллагсдын тоо	26.00	26.00	23.00	-3.00	88.5
8	Нийт цалингийн сан	131,265,473.00	221,653,200.00	191,053,246.18	-30,599,953.82	86.2
9	Нэг ажиллагсдын дундаж цалин	5,048,672.04	8,525,123.08	8,306,662.88	-218,460.20	97.4
10	Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал	1.20	0.95	0.97	0.02	102.0
11	Нийт авлага	15,166,522.59	-	3,973,400.00	3,973,400.00	
12	Нийт өглөг	4,285,768,957.97	-	15,518,517,131.51	15,518,517,131.51	
12.1	Богино хугацаат өр төлбөр	4,285,768,957.97		15,518,517,131.51	15,518,517,131.51	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн тайланд нийт 4.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнаснаас 3.2 сая төгрөгийн авлага нь шүүхийн шатанд, 0.8 сая төгрөг нь 2019 оны 12 сарын 25-ны борлуулалттай холбоотой авлага байна. Нийт 56.5 сая төгрөгийн өглөгөөс 56.0 сая төгрөгийн өглөг нь татварын өр ба үүнээс 43.5 сая төгрөг нь 2019 онд 2014-2018 оны баримтад хийсэн татварын шалгалтаар тогтоосон актын төлбөр байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Оюундэлгэр
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхой тусгаж шинэчлээгүй, санхүүгийн программ хуучирсан, сайжруулалт хийгдээгүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Оюундэлгэр
	Дүн	-			

